

ТӨСЛИЙН НЭР: “Хамтдаа хөгжицгөө” эцэг эхийн цаг

Хэсэг I. Төсөл санаачлагчийн мэдээлэл

Аймаг, хот: Өвөрхангай аймаг
Сум/дүүрэг: Хархорин сум
СЭЭБХ-ны хаяг: Орхон сургуулийн дотуур байрны 105 тоот
СЭЭБХ-ны зохицуулагч: Батжаргал овогтой Үржинсүрэн

Хэсэг IIa. Сургуулийн нөхцөл байдлын шинжилгээ

S-давуу тал	W-сул тал
<ul style="list-style-type: none">Улсын тэргүүний сургууль, аймагтаа эхний 2-3-р байранд явдаг, бага ангийн сургалт математик, монгол хэлний хичээлээр аймагтаа тэргүүлдэг.Багш нарын чадвар сайн, зэрэгтэй багш: тэргүүлэх 4, заах аргач 11 (20 багшаас).Сэтгэхүй хөгжүүлэх дугуйлан хичээллүүлдэг 11 багштай.Хүүхэд хөгжлийн өрөөтэй.“Би Монгол хүүхэд” хөтөлбөр хэрэгжүүлэх баг ажиллаж байгаа.	<ul style="list-style-type: none">Багшийн ажлын цагийн ачаалал их.Төлөвлөгдөөгүй ажил, сургалт их орж ирдэг нь хүүхэдтэй ажиллах цагийг багасгадаг.Сэтгэхүй хөгжүүлэх төлбөртэй дугуйлан хичээллүүлдэг боловч анги бүрээс цөөхөн хүүхэд хамрагддаг. Энэ нь эцэг эхийн санхүүгийн байдлаас шалтгаалдаг.Хөдөөгийн болон тавиул хүүхэд бага ангийн сурагчдын 40 хувийг эзэлдэг.Бага боловсролын хичээлийн байр төв байрнаас хол зайтай оршдог бөгөөд сургалтын хэрэглэгдэхүүн, бичиг баримт хэвлэх, олшруулахад хүндрэлтэй байдаг.
O-боломж	T- эрсдэл
<ul style="list-style-type: none">Төсөл хэрэгжсэнээр бага ангийн 526 сурагч бүгд IQ хөгжүүлэх үйл ажиллагаанд хамрагдан, сэтгэх чадвар дээшлэхЭцэг эхтэй хамтран ажиллахСум, орон нутгийн засаг захиргаатай хамтран ажиллах,Хөдөөгийн эцэг эхийг татан оролцуулахДотуур байранд амьдардаг хүүхдүүдэд зориулсан” Монгол ёс заншлын өргөө” байгуулах боломжтойСэтгэхүй хөгжүүлэх дугуйланд хичээллэж чадахгүй байгаа хүүхдүүд эцэг эхтэйгээ хамтран	<ul style="list-style-type: none">Эцэг эхийн боловсролын түвшин, ажлын цагийн хуваарь, амьдралын нөхцөл зэргээс шалтгаалан хүүхэдтэйгээ хамтран хичээл давтах, туслах боломж муу, эцэг эхэд хүндрэл учруулдаг.Багш нар эцэг эхийг сургуулийн үйл ажиллагаанд оролцуулах, хамтран ажиллах арга замаа сайн мэддэггүй.Тавиул болон дотуур байранд амьдардаг хүүхдийн эзлэх тоо их (526 хүүхдийн 40%, үүнээс дотуур байранд 48 хүүхэд, 78 хүүхэд айлд амьдардаг) учраас эцэг эхийн

Үндэсний тоглоом наадгайгаар тоглонгоо хөгжих боломж бүрдэнэ.	оролцоо бүрэн хангагдахгүй байх эрсдэлтэй.
---	--

Хэсэг IIб. Төслийн зорилго, хамрах хүрээ

Зорилго	Бага боловсролын суралцагчдын унших чадварыг эцэг эхийн оролцоотой нэмэгдүүлнэ.
Хамрах хүрээ	Бага боловсролын 526 сурагч, дотуур байрны 49 сурагч, тэдний эцэг эх, асран хамгаалагч, СЭЭБХ-ны гишүүд, сургуулийн удирдлага.
Хүлээгдэж буй үр дүн	<ul style="list-style-type: none"> • Эцэг эх хүүхдийнхээ унших, уншсанаа ойлгох, ойлгосноо ярих чадварыг сайжруулахад оролцдог болно. • Эцэг эх хүүхдийнхээ түвшинг мэдэж, ахицыг үнэлдэг болно. • Багштай харилцах дэвтэр хөтөлж, хүүхдэдээ зөвлөн туслах арга барилд суралцана. • Өөрсдийн нөөц бололцоогоор оньсон тоглоом бүтээдэг, хүүхдүүдтэйгээ тоглож ярилцдаг болсноор гэр бүлд халуун дулаан уур амьсгал бүрдүүлнэ. • Хүүхэд тоглох явцдаа өөрөө оролцон мэдлэг бүтээх нь дадал болж сурах хүсэл тэмүүлэл өрнөнө. • Хүүхэд цээжээр тоо бодох, тооцоолон бодох чадвартай болж, өөрийгөө илэрхийлж сурна. • Хүүхдийн хэвшмэл сэтгэлгээг эвдэж, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэн, түргэн сэтгэх, багаар ажиллах чадвартай болсноор сурах сонирхол нэмэгдэн өөртөө итгэлтэй болно. • Гэртээ эцэг эх, гэр бүлийнхэнтэйгээ оньсон тоглоом, сэтгэхүйн тоглоом, хөлөгт тоглоомоор тоглож, тухайн тоглоомын тухай уншиж мэдсэнээр цахим орчноос хамгаалах чухал арга болж хүүхдийн эрүүл мэнд хамгаалагдана. • Багшийн ажилд гарын авлага нэмэгдэн, эцэг эхтэй хамтран ажиллах арга зүйтэй болно. • Төсөл хэрэгжиж дууссаны дараа Монгол хэлний сургалтад эцэг эхийн оролцоог хангасан хөтөлбөртэй “Хүүхдийн сэтгэхүй хөгжсөн” сургууль болно.

Хэсэг III. Төслийг хэрэгжүүлэх зохион байгуулалт ба үйл ажиллагааны төлөвлөгөө

№	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн	Хугацаа	Хүрэх үр дүн
1.	Төсөл хэрэгжүүлэх бэлтгэл ажил	СЭЭБХ-ны Удирдах зөвлөлийн (УЗ) гишүүд	2019.1.2-14	Төслийн баг хийх ажлаа төлөвлөх уулзалтууд: <ul style="list-style-type: none"> • Төслийн нээлтийн үйл ажиллагааны

				<p>хагас өдрийн хөтөлбөр боловсруулж, оролцогчдын жагсаалт гаргах, зохион байгуулах байрыг тодорхойлно.</p> <ul style="list-style-type: none"> • Сэтгэхүй хөгжүүлэх төвүүдийн сургалт, тоглоом наадгайг интернэтээр судалж, сонгоно.
2.	Сургалтад оролцох, монгол наадгай худалдан авах	СЭЭБХ-ны Зохицуулагч Б.Үржинсүрэн, УЗ-ийн дарга Э.Мөнхзул, УЗ-ийн гишүүн Д.Алтанбороо	2019.6-р сард	<ul style="list-style-type: none"> • СЭЭБХ-ны гишүүн 3 эцэг эх Улаанбаатарт сургалтад хамрагдана. • Сонгосон тоглоом наадгай, ярьдаг ном худалдан авна.
3.	Төслийн нээлтийн үйл ажиллагаа	СЭЭБХ-ны УЗ-ийн гишүүд	2019.6-р сард	<ul style="list-style-type: none"> • Сум, сургуулийн болон бусад сургуулийн удирдлага, эцэг эх, багш, ажилтан, сурагчдын төлөөллийг урьж оролцуулна. • Төслийн талаарх ойлголт өгч, зорилго, үйл ажиллагаа, хүрэх үр дүн, тогтвортой байдлыг танилцуулна.

4.	Бага боловсролын багш нартай гэрээ байгуулах	СЭЭБХ-ны Зохицуулагч Б.Үржинсүрэн, У 3-ийн гишүүн Д.Батчулуун Э.Мөнхзул О.Даваахүү	2019.9-р сард	<ul style="list-style-type: none"> • СЭЭБХ-ноос гэрээ боловсруулна. • Гэрээний дагуу 10 кабинетийн багштай хамтран ажиллана. • Үүнд тоглоом наадгайн бүрэн бүтэн байдалд анхаарах, эцэг эхчүүдийг тоглоом наадгайгаар хүүхэдтэйгээ тоглох арга зүйн сургалтанд хамруулна. • Ангийн эцэг эх, багш нар тоглоомыг хүлээн авч бүртгэлжүүлнэ.
5.	“Эцэг эхтэй харилцах дэвтэр” аялуулах товч танилцуулга, тоглоомын мэдээллийн багц боловсруулж бэлтгэх	СЭЭБХ-ны УЗ-ийн гишүүд	2019.9-р сард	<ul style="list-style-type: none"> • “Эцэг эхтэй харилцах дэвтэр” аялуулах эцэг эх, багшид зориулсан товч танилцуулга боловсруулна. • Тоглоом бүрийн мэдээллийг хүүхдэд ойлгомжтой хэлбэрээр хүртээмжтэй бэлтгэнэ. • Тоглоомын мэдээллийг хүүхэд тоглоомоо тоглохоос өмнө уншиж, ойлгосны дагуу эцэг эхтэйгээ ярилцан тоглох учраас хүүхдийн насны онцлогт тохируулан бэлтгэнэ. • Үүнд тоглоомын гарал үүслийн

				тухай яриа, домог, үлгэр, хэрхэн тоглодог, ямар ач холбогдолтой зэргийг тусгана.
6.	<p>1-р ангийн эцэг эхэд сургалт хийх:</p> <ul style="list-style-type: none"> • 3, 6 модны оньсон тоглоомын болон эртний Хархорин хотын мэдээлэлтэй багц, (үзсэн үсгийн хэмжээнд унших үг, холбоо үг, өгүүлбэрээр тайлбарласан)-ийг хүүхдээр уншуулах арга зүйг заана. • “Эцэг эхтэй харилцах дэвтэр” аялуулж, хүүхдийн ахицыг тэмдэглэх зөвлөмж өгнө. 	СЭЭБХ-ны гишүүн эцэг эх Э.Мөнхзул, Д.Хишигмаа 1-р ангийн 4 бүлгийн багштай хамтран явуулна.	2019.9-р сард Бямба гараг, Б байрны Биеийн тамирын зааланд	<ul style="list-style-type: none"> • Эцэг эх “Эцэг эхтэй харилцах дэвтэр”-ийг хөтлөх талаар ойлгож авна. • Суралцагч үсгээ нүдлэх, холбож унших чадвар сайжирна. • Өөрийгөө илэрхийлэх чадвартай болно. • Ой тогтоолт, анхаарал төвлөрөлт сайжирч сэтгэхүй хөгжинө.
7.	<p>2-р ангийн эцэг эхэд сургалт хийх:</p> <ul style="list-style-type: none"> • “Асуудаг ном”-ны сэдвүүдийг гэртээ минутын уншлагаар уншуулж, ахицыг тэмдэглэн “Эцэг эхтэй харилцах дэвтэр”-т хүүхдийн ахицыг тэмдэглэх зөвлөмж өгнө. • 6, 9 модны оньсон тоглоомын болон эртний Хархорин хотын мэдээлэл (унших үг, холбоо үг, өгүүлбэрээр тайлбарласан)-ийг хүүхдээр уншуулах арга зүйг заана. 	СЭЭБХ-ны гишүүн эцэг эх Д.Батчулуун, Б.Шинэтуяа 2-р ангийн 4 багштай хамтран явуулна.	2019.9-р сард Бямба гараг, А байрны Биеийн тамирын зааланд	<ul style="list-style-type: none"> • Хүүхдийн унших чадвар ахиснаар эх сэдвийг уншаад ойлгосныг үнэлэх 1-6 оноотой асуултуудад хариулах, ярих чадвар нэмэгдэнэ. • 6, 9 модны 12 жилийн толгой бүхий оньсон тоглоом, Үйчүүр тоглоомын тухай мэдлэгтэй болно. • Цээжээр тоо бодох, тооцоолон бодох, бүтээлчээр сэтгэх чадвар хөгжинө.

8.	<p>3-р ангийн эцэг эхэд сургалт хийх:</p> <ul style="list-style-type: none"> • "Ярьдаг ном"-ны сэдвүүдээр минутын уншлага хийх аргачлал заана. • Тоглоомын болон эртний Хархорин хотын мэдээлэлтэй багц • Уншлагын хурдны ахицыг тэмдэглэн, "Эцэг эхтэй харилцах дэвтэр" дэвтэр хөтлөх аргачлалд суралцана. 	<p>СЭЭБХ-ны УЗ-ийн гишүүд Д.Норжинсүрэн, О.Даваахүү бүлгийн 4 багштай хамтран явуулна.</p>	<p>2019.10-р сард Бямба гараг, Дотуур байрны уншлагын танхимд</p>	<ul style="list-style-type: none"> • Унших хурд нэмэгдэнэ. • Уншсанаа ярих чадварыг хөгжүүлнэ. • 18, 25 модны оньсон тоглоом, 7 дүрстэй танграм "Долоодой", Оюунтүлхүүр, Үйчүүр тоглоомын тухай мэдлэгтэй болно. • Нэг зүйлийг олон өнцгөөс нягтлан дүгнэх, түргэн сэтгэх чадвар хөгжинө.
9.	<p>4-р ангийн эцэг эхэд сургалт хийх:</p> <ul style="list-style-type: none"> • "Ярьдаг ном"-ны сэдвүүдээр минутын уншлага хийх аргачлал заана. • Уншлагын хурдны ахицыг тэмдэглэн, "Эцэг эхтэй харилцах дэвтэр" дэвтэр хөтлөх аргачлалд суралцана. • Тухайн сэдвүүдээр найруулан бичлэг хийх, зохион бичих аргачлалын талаар эцэг эхэд мэдээлэл өгнө (төгсгөл нь ямар байх вэ? гэх мэт). • 12 жил, Монгол орны газрын зургийн эвлүүлгээр хийсэн бодит оньсон 	<p>СЭЭБХ-ны гишүүн Д.Алтантуяа, Э.Энхцэцэг, Бүлгийн 4 багштай хамтран явуулна.</p>	<p>2019.10-р сард А байрны Биеийн тамирын зааланд</p>	<ul style="list-style-type: none"> • Унших хурд нэмэгдэнэ. • Уншсанаа ярих чадварыг хөгжүүлнэ. • Хүүхдийн зөгнөлт сэтгэлгээ, бүтээлчээр сэтгэх чадвар хөгжинө. • Бичих, төлөвлөх, зохион бичих чадвартай болно. • Танин мэдэхүйн чадвар, анхаарлаа төвлөрүүлэх, багаар ажиллах чадвар хөгжинө.

	<p>тоглоомоор тоглох,</p> <ul style="list-style-type: none"> • Тоглоомын болон эртний Хархорин хотын мэдээлэлтэй багцыг хүүхдээр уншуулж, ярилцах аргачлалд суралцана. 			
10.	<p>5-р ангийн эцэг эхэд сургалт хийх:</p> <ul style="list-style-type: none"> • Сонирхсон сэдвүүдээр минутын уншлага хийлгэх, тэмдэглэл хөтлөх, бусдад ярих чадвар эзэмшүүлэх талаар ойлголт өгнө. • “Эцэг эхтэй харилцах дэвтэр” дэвтэр хөтлөх аргачлалд суралцана. • 40 модны оньс, төмөр оньсон тоглоомын болон эртний Хархорин хотын мэдээлэлтэй багцыг хүүхдээр уншуулж, ярилцах аргачлалд суралцана. 	<p>СЭЭБХ-ны Зохицуулагч Б.Үржинсүрэн, М.Жаргалмаа 5-р ангийн 4 багштай хамтран сургалт явуулна</p>	<p>2019.10-р сард Б байрны биеийн тамирын зааланд</p>	<ul style="list-style-type: none"> • Унших хурд нэмэгдэнэ. • Уншсанаа ярих, илтгэх чадварыг хөгжүүлнэ. • Бусдыг сонсох, анхаарлаа төвлөрүүлэх, багаар ажиллах, аливаад дүгнэлт хийх, задлан шинжлэх, эрэл хайгуул хийх бүтээлч чадвар суулгана. • Илтгэлийн анхны сонсогч нь эцэг эх, гэр бүл нь байх болно. • Хэл ярианы унших, бичих, сонсох, ярих 4 чадвар зэрэг хөгжинө.
11.	<p>Дотуур байрны багш, жижүүр, байрны зөвлөлийн сурагчдад сургалт хийх:</p> <ul style="list-style-type: none"> • 1-5-р ангийн 49 хүүхдийг анги бүрээр дээрх аргачлалаар ажиллахыг заана. • тоглоомын болон эртний Хархорин хотын 	<p>СЭЭБХ-ны УЗ-ийн дарга Э.Мөнхзул, гишүүн Д.Алтантуяа, Э.Энхцэцэг</p>	<p>2019.10 Ням гараг, Дотуур байрны уншлагын танхимд</p>	<ul style="list-style-type: none"> • Дотуур байрны хүүхдүүд хичээлээс хоцрохгүй байх нөхцөл бүрдэнэ. • Чөлөөт цагаа зөв зохистой өнгөрүүлдөг болно. • Оньсон тоглоомоор тоглонгоо сэтгэх

	<p>мэдээлэлтэй багцыг уншуулах,</p> <ul style="list-style-type: none"> • “Эцэг эхтэй харилцах дэвтэр” дэвтэр хөтлөх аргачлалд суралцана. 			<p>чадвар нь хөгжинө.</p> <ul style="list-style-type: none"> • Байрны багш, жижүүр багш нар хуваарийн дагуу хүүхдүүдтэй ажиллана. • Дунд, ахлах ангийнхны зүгээс зөв хандлага төлөвшиж, дүү нартаа зөвлөн туслах сэтгэл зүйн таатай орчин бүрдэнэ.
12.	<p>Эцэг эх, багш хамтран өөрийн ангийн төлөвлөгөө боловсруулах: Ангид тоглох, тоглоомыг хүүхдэд гэрээр өгч явуулах хуваарь гаргах, хүртээмжтэй болгох үүднээс гарын ур дүйтэй эцэг эх, ахлах ангийн сурагчидтай хамтран тоглоомыг шинээр хийх баг гаргах</p>	<p>СЭЭБХ-ны зохицуулагч Б.Үржинсүрэн, сургалтын менежер Ж.Бадамгарав</p>	<p>2019.9-10-р сар</p>	<ul style="list-style-type: none"> • Хүүхэд бүрт олон төрлийн тоглоом хүртээмжтэй болгох нөхцөл бүрдэнэ. • Эцэг эх, багшийн хамтын ажиллагаа сайжирна. • Хөдөлмөрийн хичээлийн багш, сурагчид эцэг эхтэй хамтран ажиллана. • Эцэг эх хөдөлмөрийн кабинетийн хөрөө багажыг ашиглаж, хүүхдүүддээ тоглоом бүтээж, тоглох арга зүйд тусалж байнгын харилцаа явагдана.
13.	<p>Анги бүр төлөвлөгөө, хуваарийн дагуу тоглоомын үйл ажиллагааг зохион байгуулах</p>	<p>СЭЭБХ-ны УЗ-ийн гишүүн Д.Батчулуун, Э.Мөнхзул, Д.Алтантуяа, Э.Энхцэцэг, Д.Алтанбороо, О.Даваахүү, АУБ нар</p>	<p>2019.10-2020.10-р сар Цаашид уламжлал болно</p>	<ul style="list-style-type: none"> • Эцэг эхчүүд анги, дотуур байр, гэртээ хуваарийн дагуу сэтгэхүй хөгжүүлэх тоглоомоор хүүхдүүдтэй хамтран тоглож ярилцана.

				<ul style="list-style-type: none"> • Багш нар хичээлийн үйл ажиллагаанд ашиглана.
14.	Төслийн дунд хугацааны үнэлгээний хуудас боловсруулах, үнэлгээ хийх	СЭЭБХ-ны Зохицуулагч, УЗ-ийн гишүүд сургалтын менежер, нийгмийн ажилтан	2019.12-р сар	<ul style="list-style-type: none"> • Суралцагчдын сурлагын чанарын ахиц • Эцэг эхийн оролцоог тооцох • Сурагч, эцэг эх, багш тус бүрээр ярилцлагын товч асуулт бэлдэх • Боловсруулсан үнэлгээний хуудсаар эцэг эхийн оролцоо, сурлагын чанарын ахицыг тооцож туршлага болох үйл ажиллагааг илрүүлэх, сурталчлах, бусад ангиудад түгээн дэлгэрүүлэх ажил зохион байгуулна.
15.	“Би чадна, Бид чадна” өдөрлөг, Үсэглэлийн баяр, Тоглоомын баяр 1-3-р ангийнхны дунд зохион байгуулах	СЭЭБХ-ны Зохицуулагч, УЗ-ийн гишүүд	2019.12-р сар, 2020.5-р сар 2 удаа	<ul style="list-style-type: none"> • Минутын уншлага, • “Эцэг эхтэй харилцах дэвтэр” дэлгэн үзүүлэх • Хүүхэд бүр үсэг болж, тухайн үсэг орсон шүлэг, найраглалын хэсгээс унших • Насны онцлогт тохирсон модон оньсон тоглоом, Оюун түлхүүр наадмаар сурч мэдсэнээрээ тоглолт үзүүлнэ. • Сурагчдын бүтээлийн үзэсгэлэн гаргана.

16.	4-5-р ангийнхны дунд Хэн хурдан сэтгэдэг вэ? өдөрлөг, Эрдмийн баяр тэмдэглэх	СЭЭБХ-ны УЗ-ийн гишүүд, Эцэг эхин төлөөлөл	2019.12-р сар, 2020.5-р сар 2 удаа	<ul style="list-style-type: none"> • 4-р ангийн сурагчдыг баг болгон танил биш сэдэв өгч “Цааш нь яаж өрнөх вэ?” зохиомж бичүүлэх, санамсаргүй тохиолдлын аргаар сонгож анги бүрээс 1-2 зохиомжийг дэлгэцээр харуулна. • 5-р ангийн сурагчдад сэдэв өгч богино хэмжээний илтгэл бичүүлэх: анги бүр 4 багт хуваагдан илтгэл бичиж хамтран илтгэнэ. • Насны онцлогт тохирсон модон оньсон тоглоом, Оюун түлхүүр наадмаар сурч мэдсэнээрээ үзүүлэх тоглолт хийнэ. • Сурагчдын бүтээлийн үзэсгэлэн гаргана.
17.	Анги бүрийн сурагч, эцэг эхчүүдтэй уулзалт зохион байгуулах	СЭЭБХ-ны гишүүд: Э.Мөнхзул Э.Энхцэцэг Д.Норжинсүрэн Б.Амарзаяа Б.Шинэтуяа	2019.12-р сар	<ul style="list-style-type: none"> • Ангиудын “Монгол наадгайн булан”-гийн үйл ажиллагаатай танилцана. • Сурагч, багштай ярилцаж, дунд хугацааны үнэлгээтэй харьцуулна.
18.	Бага боловсролын суралцагчдын сурлагын чанарын харьцуулалт гаргах	Сургалтын менежер, АУБ нар	2020.9-10-р сар	<ul style="list-style-type: none"> • Сурагчдын 2018-2019 оны 4-р улирлын дүнг 2019 -2020 оны

				2-р улирлын дүнтэй харьцуулсан үзүүлэлтийг гаргаж СЭЭБХ-нд өгнө.
19.	Төслийн тайлант өдөрлөг	СЭЭБХ-ны зохицуулагч Б.Үржинсүрэн УЗ-ийн дарга Э.Мөнхзул СЭЭБХ-ны УЗ-ийн гишүүд	2020.10-р сар	<ul style="list-style-type: none"> • Сурагчдын 2018-2019 оны 4-р улирлын дүнг 2019-2020 оны 1-р улирал болон хагас жилийн дүнтэй харьцуулсан үзүүлэлт • Төслийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулна. • Төслийн хугацаанд гарсан суралцагчдын сурлагын чанарын өөрчлөлтийг танилцуулна. • Суралцагчдын сэтгэхүйн тоглолт үзүүлнэ • Сум, сургууль, бусад сургууль, байгууллагуудын удирдлага, эцэг эх, суралцагчид оролцоно.

Хэсэг IV. Үйл ажиллагааны зардлын задаргаа

Зардлын төрөл		Хэмжих нэгж	тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Хүрэх үр дүн
1. Үйл ажиллагааны зардал	Бичиг хэргийн зардал:	Боодол	15	11000₮	165.000₮	Төслийн болон СЭЭБХ-ны танилцуулга, тоглоомын мэдээлэл, тоглох журам, монгол хэлний тараах материал, урилга, брошюр хэвлэх Сургалтанд зориулж Тайлан мэдээ өгөх, хэрэгтэй мэдээлэл татаж авах, бусад СЭЭБХ, СЭЭБҮНХ-той мэдээлэл солилцох, УЗ-ийн гишүүдэд утасны нэгж авах Гэрээ, үнэлгээний хуудас, хөтөлбөр боловсруулах гэх мэт уулзалтад цайны материал авах Урилга хийх, цайны материал авах Тараах материал олшруулах, цайны материал авах Цайны материал авах Урилга хийх, цайны материал авах
	Бичгийн цаас		30	5000₮	150.000₮	
	Ламинатор цаас					
	Тосон бал	ш	100	800₮	80.000₮	
	Интернет, харилцаа холбоо	сар	20	25000₮	500.000₮	
		хүн	9	2000₮	360.000₮	
	Уулзалтын зардал	20 сар	20	30000₮	600.000₮	
	Төслийн нээлт	удаа	1	250500	250500₮	
	Сургалтын зардал	удаа	2	100.000₮	200.000₮	
	Өдөрлөг	удаа	2	125.000₮	250.000₮	
Тайлангийн өдөрлөг		1	220.000	220.000₮		
Банкны шимтгэл				21.700₮		
Нийт					2.797.200₮	
2. Сургалтын материал болон хэрэглэгдэхүүний	Үйчүүр тоглоом	ш	24	22000₮	528.000₮	10 кабинет, дотуур байр тус бүрт 2ш худалдан авч өгнө. Эцэг эхчүүд хамтран нэг ангид 4 хүүхдэд нэг тоглоом оногдох тоогоор хийж хүртээмжтэй болгоно. Цээжээр тоо бодох, тооцоолон бодох, түргэн сэтгэх, багаар ажиллах чадвар хөгжинө.

	Оюунтүлхүүр	ш	66	8800₮	580.000₮	Аливаад тэвчээртэй, түргэн сэтгэх, анхаарал төвлөрөх чадвар хөгжинэ.
	Модны оньс	ш	100	8800₮	880.000₮	Хүүхдийн хэвшмэл сэтгэлгээг өөрчлөн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлнэ.
	Нийт				1.988.000₮	
3.Сургалт болон зөвлөх үйлчилгээний зардал	Замын зардал	Хүн нэгж	3	19800₮	118800₮	Автобусны зардал нэг талдаа 19800₮, 3 хүний 59400₮, нийт 118800₮
	Томилолт		3	90000₮	180000₮	Нэг хүн өдөрт 30000₮ 2 өдрийн зардал 90000₮, нийт 180000₮
	Сургалтын төлбөр		3 хүн 10 цаг	13800	132800₮	Нэг хүний сургалтын зардал өдөрт 66000₮, 3 хүний 198.000₮. Нэг хүн өдөрт 3 цаг нь 33000₮, нийт 6 цагийн сургалт авна.
	Нийт				431.600₮	
Нийт					5.216.800₮	2000\$-ын 03 сары н 07 –ны өдрийн ханшаар тооцоолон 2641 төгрөгөөр тооцов.

Хэсэг VI. Төслийн тогтвортой байдал

1. Хүүхэд бие даан суралцах, багаар ажиллах чадвар эзэмшин сурлагын чанар бүх хичээлээр ахина.
2. Хүүхэд сургууль, дотуур байр болон гэртээ найз нөхөд, эцэг эх, гэр бүлийнхэнтэйгээ сэтгэхүйн олон төрлийн тоглоомоор тоглох нь цахим орчноос хамгаалах чухал арга болж, хүүхдийн эрүүл мэнд хамгаалагдана.
3. Бага ангийн 10 кабинет, дотуур байр сэтгэхүй хөгжүүлэх тоглоомын булантай болно.
4. СЭЭБХ-ны тоглоом хийх аргад суралцан тоглоомын буланг баяжуулна.
5. СЭЭБХ-ны гишүүд тоглоомын зааврын багцаа баяжуулан боловсруулж сурна.
6. СЭЭБХ-ны гишүүд сэтгэхүй хөгжүүлэх тоглоомын арга зүйд суралцан 1-р анги болон шилжин ирсэн суралцагчдын эцэг эхэд зөвлөн тусалж, хамтран ажилладаг болно.
7. Анги удирдсан багш нарын эцэг эхтэй ажиллах шинэ хэлбэрийг хөгжүүлнэ.
8. Жил бүр сургуулийн хичээлээс гадуурх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган, эцэг эхийн оролцоог нэмэгдүүлнэ.

Эцэг эхтэй харилцах дэвтрийн загвар:

“Хүүхдийн хөгжилд эцэг эхийн дэмжлэг”

ӨВ. Хархорин сумын Орхон сургуулийн -----ангийн -----бүлгийн сурагч
-----ны эцэг эхтэй харилцах дэвтэр

2019-2020 он

№	Сар/ өдөр	Эцэг эхийн тэмдэглэл				Тухайн өдөр хүүхэдтэй ажилласан эцэг эхийн гарын үсэг
		Сэдвийн нэр	Хэдэн үг уншсан /1мин/	Онъсон тоглоом эвлүүлэх, задлах		
				Хэдэн модны /тоглоомны нэр/	Мин/сек	
1	10/03	Хар морь	95	6 модны 12 жилийн үхэр, туулай 2	3мин/10сек	
2	20/03					
3	9/04					
4	19/04					
5	29/04					
6	9/05					
7	19/05					
8	29/05					

7 хоног тутам бямба гарагт 11 -14 цагийн “Хамтдаа тоглоё” эцэг эхийн цаг гарган анги бүр 4 эцэг эх ангид ирж хүүхдийг тэнцүү хуваарилан авч Үйчүүр тоглуулан , Оюун түлхүүр гархи , модон онъсон тоглоом эвлүүлэхэд туслан зааж өгч байх зохион байгуулалт хийхээр багш эцэг эхтэй ярилцан тохиролцлоо.